



СЭЛЭНГЭ АЙМАГ
БАЯНГОЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2018 оны 07 сарын 08 өдөр

Дугаар А/141

Баруун хараа

Бэлчээрийн газар ашиглуулах тухай

Монгол Улсын Газрын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.4.3 дахь, 44 дүгээр зүйлийн 44.8, 52 дугаар зүйлийн 52.2 дахь заалт 2017 оны сумын ИТХ-ын 38 дугаар тогтоолыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Макс Агро ХХК нь Баянгол сумын Гонир 3 дугаар баг Өлөнтийн аманд бэлчээрийг хашиж хамгаалах, ашиглах эрчимжсэн үхрийн аж ахуйдаа дэмжлэг үзүүлэх зорилгоор газар ашиглах хүсэлт ирүүлснийг тэмдэглээд дараах солбицолд тусгагдсан 2077 га бэлчээрийн газрыг 5 жилийн хугацаатайгаар гэрээгээр ашиглуулсугай.

Үүнд: Макс Агро ХХК-ийн гэрээгээр ашиглах газрын байршил

| | Уртраг | Өргөрөг |
|----|----------------|---------------|
| 1 | 106° 23' 14.9" | 48° 57' 48" |
| 2 | 106° 23' 12.2" | 48° 57' 43" |
| 3 | 106° 24' 44.8" | 48° 58' 11.7" |
| 4 | 106° 25' 26.3" | 48° 58' 30" |
| 5 | 106° 26' 22.8" | 48° 58' 28" |
| 6 | 106° 27' 1.1" | 48° 58' 52.8" |
| 7 | 106° 26' 15.1" | 48° 59' 51.4" |
| 8 | 106° 26' 8.7" | 49° 00' 46.9" |
| 9 | 106° 27' 28.7" | 49° 01' 0.3" |
| 10 | 106° 28' 5.3" | 49° 00' 32.1" |
| 11 | 106° 28' 8.4" | 48° 59' 27.8" |
| 12 | 106° 29' 23.9" | 48° 59' 24.7" |
| 13 | 106° 29' 21.7" | 48° 57' 41.1" |

2. Макс Агро ХХК-ийн гүйцэтгэх захирал /О. Галбадрах/-д даалгах нь:

а/ Бэлчээрийн газрыг зориулалтын дагуу ашиглах, байгаль орчныг хамгаалах хууль тогтоомж болон газар ашиглахтай холбогдсон нийтлэг шаардлагыг биелүүлэх

б/ Газрын төлөв байдал, чанарын хянан баталгаа хийлгэх

в/ Газрын хил заагийг тэмдэгжүүлж эрх бүхий мэргэжлийн байгууллагаар кадастрын зураглал хийлгэж мэдээллийн санд оруулах

г/ 5-аас дээш га газарт олон настын ургамал тариалах нөхцөлд сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлаар оруулж атар газар хагалах зөвшөөрөл холбогдох байгууллагаас авах

3. Макс Агро ХХК-ийн гэрээгээр ашиглаж байгаа бэлчээрийн газарт хяналт тавьж жилд 1 удаа гэрээг дүгнэж ажиллахыг Гонир 3 дугаар багийн Засаг дарга /Б. Болортуяа/, байгаль орчны хяналтын улсын байцаагч /М. Бумцэнд/, газрын даамал /Г. Саранцэцэг/ нарт үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

С. АРИУНБАТ